

Нэгтгэсэн төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/12 дугаар зүйлийн 12.1.7 дахь заалт:

"12.1.7.бусад орлого."

2/12 дугаар зүйлийн 12.2.11 дэх заалт:

"12.2.11.уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийг бууруулахад дэмжлэг үзүүлэх."

3/14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэг:

"14.6.Энэ хуулийн 14.5.2-т заасан хөнгөлөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулах журмыг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

2 дугаар зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.2, 6 дугаар зүйлийн 6.4.2, 12 дугаар зүйлийн гарчиг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн "Байгаль хамгаалах сан" гэснийг "Байгаль орчин, уур амьсгалын сан" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг